

Зэрэг тогтоох

Шалгууруудын хоорондын холбоо харилцааг дүр загвараар үзүүлэх:

УСТСАН (У)

Хамгийн сүүлчийн бодгаль маргаангүйгээр үхсэн бол тухайн ангилал зүйн нэгжийг “Устсан” гэсэн ангилалаар үнэлдэг. Өухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчингуудыг тохиромжтой цаг хугацаанд (өдрийн, улирлын, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд мөн тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг “Устсан” гэсэн ангилд оруулна. Судалгааг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдуулсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.

БАЙГАЛЬД УСТСАН (БУ)

Тухайн зүйлийн бодгалиуд зөвхөн таримал байдлаар амьдарч байгаа, хэрэв зэрлэг амьтан бол тэжээмэл байдлаар үржиж байгаа эсвэл тухайн амьтны популяцийг (популяциудыг) урьд нь тархаж байсан тархац нутгийн гадна талд байгалийн нөхцөлд нь байлгаж байгаа бол “Байгальд Устсан” гэсэн ангилалд оруулдаг. Тухайн зүйлийн бодгаль байж болох амьдрах орчингуудыг тохиромжтой цаг хугацаанд (өдрийн, улирлын, жилийн идэвхийг харгалзан) нарийн судалж үзээд мөн тухайн зүйлийн өмнө нь тархаж байсан бүх газар нутгаар судалгаа хийж үзээд нэг ч бодгаль илрүүлээгүй тохиолдолд тухайн зүйлийг “Байгальд Устсан” гэсэн ангилд оруулна. Судалгаануудыг зүйлийн амьдралын эргэлт ба амьдралын хэлбэртэй уялдуулсан цаг хугацаанд гүйцэтгэсэн байх ёстой.

УСТАЖ БАЙГАА (УБ)

Тухайн зүйлийн талаарх байгаа бүх баримтууд А -гаас Е хүртэлх аль нэг шалгуураар “Устаж Байгаа” (Бүлэг V-г харна уу) гэсэн ангилалаар үнэлэгдэж байгаа бол байгальд устах эрсдэл туйлийн өндөр байгааг илтгэдэг бөгөөд “Устаж Байгаа” гэсэн ангилалд оруулдаг.

УСТАЖ БОЛЗОШГҮЙ (УБo)

Тухайн зүйлийн талаарх баримтуудыг А -гаас Е хүртэлх шалгуураар шалгахад “Устаж Болзошгүй” (Бүлэг V-г харна уу) гэсэн ангиллаар үнэлэгдсэн зүйл нь байгаль дээр устах эрсдэл өндөр байгаад тооцогддог бөгөөд “Устаж Болзошгүй” гэсэн ангилалд оруулна.

ЭМЗЭГ (Э)

Тухайн зүйлийн талаарх баримтуудыг А -гаас Е хүртэлх шалгуураар шалгахад “Эмзэг” (Бүлэг V-г харна уу) гэсэн ангилалаар үнэлэгдэж байвал тухайн зүйл байгальд устах эрсдэл өндөртэй байгаад тооцогдож “Эмзэг” гэсэн ангилалд орно.

ХОВОРДОЖ БОЛЗОШГҮЙ (ХБ)

Тухайн зүйлийг А -гаас Е хүртэлх шалгууруудаар шалгаж үзэхэд Устаж Байгаа, Устаж Болзошгүй, Эмзэг гэсэн ангиллаар үнэгдэх боломжгүй боловч ойрын ирээдүйд устаж, ховордож байгааг илэрхийлсэн дээрх ангилуудын аль нэгд ороход ойр байгаа зүйлийг “Ховордож Болзошгүй” гэсэн ангилалаар үнэлдэг.

АНХААРАЛД ӨРТӨХӨӨРГҮЙ (АӨ)

Тухайн зүйлийг А -гаас Е хүртэлх шалгууруудаар шалгаж үзэхэд Устаж Байгаа, Устаж Болзошгүй, Эмзэг эсвэл Ховордож Болзошгүй гэсэн ангиллуудын аль нэгээр үнэгдэх боломжгүй тул “Анхааралд Өртөхөөргүй” зүйл гэсэн ангиллаар үнэлдэг. Өргөн тархалттай, арви өндөртэй зүйл энэ ангилалд ордог.

МЭДЭЭЛЭЛ ДУТМАГ (МД)

Тухайн зүйлийн популяцийн статус болон тархалтын байдалд үндэслэн устах эрсдэлийг тогтоох шууд ба шууд бус үнэлгээ хийхэд мэдээлэл хангалтгүй байгаа үед “Мэдээлэл Дутмаг” гэсэн ангилалд оруулдаг. Энэ ангилалд орсон зүйлийн биологи сайн судлагдсан боловч тухайн зүйлийн арви, тархалтын талаар мэдээлэл дутмаг байж болно. “Мэдээлэл Дутмаг” гэсэн ангилал нь устах, ховордох эрсдлийг илэрхийлсэн ангилал биш юм. Зүйлийг энэ ангилалд оруулах нь тухайн зүйлийн талаар мэдээлэл хэрэгтэй байгааг илэрхийлдэг төдийгүй тухайн зүйлийн талаар ирээдүйд судалгаа хийгдэж тэр судалгаа нь тэр зүйлийг устах эрсдэлтэйг нотлох боломжтой байж болно. Байгаа мэдээллийг ашигтайгаар хэрэглэх нь чухал байдаг. Оухайн зүйлийг “Мэдээлэл Дутмаг” мөн Устах эрсдэлтэйг илэрхийлсэн ангиллын алинд нь оруулахаа маш анхааралтай шийдэх хэрэгтэй. Хэрэв тухайн зүйлийн тархац нутаг харьцангуй хязгаарлагдмал, тухайн зүйлийг нэлээд хугацааны өмнө судалсан бол тэр зүйлийг ховордох, устах эрдэлтэй ангилалд оруулах нь зайлшгүй зөв зүйтэй шийдвэр юм.

ҮНЭЛГЭЭ ХИЙГДЭЭГҮЙ (ҮХ)

Шалгууруудаар шалгагдаагүй зүйлийг “Үнэлгээ хийгдээгүй” гэсэн ангилалд оруулдаг.

Устаж байгаа, Устаж болзошгүй, Эмзэг зэрэглэлийн шалгуур

УСТАЖ БАЙГАА

Таксон бол Устаж байгаа хамгийн хэрэгтэй нотолгоог дараах шалгуурын А-Е аль алинд нь заан үзүүлэх бөгөөд байгаль дахь мөхлийн хэт өндөр эрсдэлийг анхааралдаа авсан.

- А. Популяцийн хэмжээнд дэхь бууралт доорхын аль нэгэнд суурилах
1. Популяцийн хэмжээний бууралт сүүлийн 10 гаруй жилд аль ч 3 үеийн турш 90%-аас их байхыг ажиглан судласан, үнэлсэн, дүгнэсэн юмуу сэжиглэсэн байх бууралтын шалтгаан нь дараахын аль нэгд нь суурилдаг онцлогтой ба тасралтгүй ба тодорхой 2 талтай.
 - a. Шууд ажиглах
 - b. Таксонд тохирсон баялагийн индекс
 - c. Эзэмшил нутаг дахь бууралт, тохиолдцын хэмжээ ба амьдрах орчны шинж чанар
 - d. Ажиглалтын бодит юмуу бололцоот түвшин
 - e. Таксоны эрлийзжүүлэг, эмгэг үүсгэгч, өрсөлдөгч юмуу паразит оруулсаны нөлөө
 2. Популяцийн хэмжээний бууралт сүүлийн 10 гаруй жилд юмуу аль 3 үеийн турш 80%-аас их байхыг ажигласан, үнэлсэн, дүгнэсэн юмуу сэжиглэсэн байх
Бууралт ба түүний шалтгаан нь тасралтгүй биш эсвэл ойлгомжтой биш байх, 2 талтай биш байх
А1-ийн доорх А-Е-ийн аль нэгэнд суурилсан
 3. Популяцийн хэмжээний бууралт нь ирэх 10 жилд юмуу аль ч 3 үеийн турш (хамгийн ихдээ 100 жил) 80%-аас их байхыг тоцолох юмуу сэжиглэсэн. А1-ийн доорх b-e-ийн аль нэгд суурилсан.
 4. Популяцийн хэмжээний бууралт аль нэг 10 жил юмуу аль ч 3 үеийн хугацаанд (ирээдүйд хамгийн дээд тал нь 100 жил) 80%-аас их байхыг ажигласан, тооцсон, дүгнэсэн, төлөвлөсөн юмуу сэжиглэсэн. Гэхдээ өнгөрсөн ба ирээдүйг багтаасан байх ёстой ба бууралт түүний шалтгаан тасралттай биш, эсвэл ойлгомжтой биш, эсвэл 2 талтай биш. А1-ийн доорх a-e-ийн аль нэгд суурилсан байна.
- В. Аль ч В1 (тохиолдлын хэмжээ) эсвэл В2 (эзэмшил нутаг) эсвэл аль алины хэлбэр дэхь газарзүйн бүс
1. Тохиолдлын хэмжээг 100км²-аас бага байхаар тооцоолсон бөгөөд a-c –ийн 2-т тооцоолон үзүүлсэн.
 - a. Хатуу ширүүн хэсэг дэхь цорын ганц байршил
 - b. Бууралтын үргэлжлэлийг ажиглаж судлах, төлөвлөсөндөө дүгнэлт хийж аль нэгийг нь баримтлах
 - I. Хэр хэмжээний тохиромжтой байдал
 - II. Газар нутгийн эзэмшил
 - III. Газар нутгийн эзэмшил болон судалгаа хийж буй газрын шинж чанар
 - IV. Дэд популяци дахь байршилын тоо
 - V. Бие гүйцсэн бодгалийн тоо
 - c. Туйлын хэлбэлзлийг ямар нэгэн байдлаар багтаах
 - I. Хэр хэмжээний тохиромжтой байдал
 - II. Газар нутгийн Эзэмшил
 - III. Дэд популяци дахь байршлын тоо

IV. Бие гүйцсэн бодгалын тоо

2. Газар нутгийн эзэмшлийн тохиолдлын хэмжээг 10км²- аас бага байхаар тооцоолох ба а-с –ийн 2т тооцоолон үзүүлсэн.

- a. Хатуу ширүүн хэсэг дэхь цорын ганц байршил
- b. Бууралтын үргэлжлэлийг ажиглаж судлах, төлөвлөсөндөө дүгнэлт хийж аль нэгийг нь баримтлах
 - VI) Хэр хэмжээний тохиромжтой байдал
 - VII) Газар нутгийн эзэмшил
 - VIII) Газар нутгийн эзэмшил болон судалгаа хийж буй газрын шинж чанар
 - IX) Дэд популяци дахь байршилын тоо
 - X) Бие гүйцсэн бодгалийн тоо
- c. Туйлын хэлбэлзлийг ямар нэгэн байдлаар багтаах
 - V) Хэр хэмжээний тохиромжтой байдал
 - VI) Газар нутгийн эзэмшил
 - VII) Дэд гүйцсэн бодгалын тоо
 - VIII) Бие гүйцсэн бодгалын тоо

C. Популяцийн эзэлхүүн тохиолдлоор цөөхөн байх, 250 бие гүйцсэн бодгаль.

- 1. Бууралт нь 25%-аар үргэлжлэх тохиолдолд 3 жилийн хугацаатай ба 1-р үед (хамгийн ихдээ 100 жил)
- 2. Бууралтын үргэлжлэлийг судлах дүгнэлт гаргах, бие гүйцсэн бодгалийг тооцох а-в-д үзүүлсэн болно.
 - a. Популяцийн бүтэц хэлбэрийг 1-рт тавих
 - I) Дэд популяци нь тохиолдлоор 50 бие гүйцсэн бодгаль байх
 - II) 1 дэд популяцид бие гүйцсэн бодгаль 90% байх

в. Туйлын хэлбэлзлийг ямар нэгэн байдлаар багтаах

D. Популяцийн эзэлхүүнд тохиолдлоор 50 бие гүйцсэн бодгаль тоологдох

E. Тоо хэмжээний хувьд анализ хийхэд устах аюулд орсон буюу боломж нь 50% байх, 10 жил буюу 3 үе (хамгийн ихдээ 100 жил)

УСТАЖ БОЛЗОШГҮЙ

Таксон бол хор хөнөөлийн хамгийн хэрэгтэй нотолгоог дараах шалгуурын А-Е аль алинд нь заан үзүүлэх бөгөөд байгаль дахь мөхлийн хэт өндөр эрсдэлийг анхааралдаа авсан

- A. Популяцийн хэмжээн дэх бууралт доорхын аль нэгэнд суурилах
 - 1. Популяцийн хэмжээний бууралт сүүлийн 10 гаруй жилд аль ч 3 үеийн турш 70%-аас их байхыг ажиглан судласан, үнэлсэн, дүгэнэсэн юмуу сэжиглэсэн байх, бууралтын шалтгаан нь дараахын аль нэгд нь суурилдаг онцлогтой ба тасралтгүй ба тодорхой 2 талтай
 - b. шууд ажиглах